



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.2.28 № 01/02 ЧНГ-САН/2014/07/СТА-ТШЗ

Түрээсийн төлбөрийг төсөвт  
төвлөрүүлэх тухай

Зам тээврийн яамны 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Улаанбаатар төмөр зам ХНН-т түрээслүүлсэн тоног төхөөрөмжийн 2012, 2013 оны түрээсийн төлбөр 399,634,588 төгрөгийг нэхэмжилж оруулаагүй зөрчил илэргээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-д Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг хувьчилсан, худалдсан, түрээслэсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, гадаад улс, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Түрээсийн төлбөр 399,634,588 (Гурван зуун ерэн есөн мянга зургаан зуун гучин дөрвөн мянга таван зуун наян найман ) Төрийн сан банкин дахь Үндэсний аудитын газрын Төсвийн орлогын 900000601 тоот дансанд 2014 оны 4 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батзаяа, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга З.Цэрэнчимэг нарт хариуцуулав.

ТОГТООСОН: АКТЫГ  
ҮАГ-ын Санхүүгийн аудитын газрын  
Ахлах аудитор  Ц.Гэрэл  
УХА0122

ЗӨВШӨӨРСӨН  
Зам тээврийн яамны  
Төрийн нарийн бичгийн дарга  
Б.Батзаяа  
СХОХ-ийн дарга, ерөнхий нягтлан  
бодогч  
 З.Цэрэнчимэг